

Аж ахуйн нэгж, байгууллагын 201... оны үйл ажиллагааны хураангуй мэдээ

А. ХАЯГИЙН ХЭСЭГ

Регистрийн дугаар									
Зөвшөөрлийн дугаар									
Байгууллагын нэр									
Байршил	Нэр				Код				
Аймаг, нийслэл									
Сум, дүүрэг									
Үйл ажиллагааны салбарын чиглэл									

1. Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллага нь жилийн эцсийн мэдээг 2 дугаар сарын 25-ны дотор аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газарт маягтаар ирүүлнэ.

2. Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь 3 дугаар сарын 1-ний дотор ЭМЯ-ны харьяа эрүүл мэндийн статистикийн асуудал хариуцсан үндэсний нэгжид цахим шуудангаар дамжуулна.

3. Үндэсний нэгж нь жилийн эцсийн мэдээг 3 дугаар сарын 12-ны дотор Үндэсний Статистикийн Хороонд цахим шуудангаар дамжуулна.

ЭМХХБ-ын төрөл	Код
Хэвтүүлэн эмчлэх эмнэлэг	01
Амбулатори	02
Лаборатори	03
Аршаан сувилал	04
Ариутгал, хортон шавьж устгал	05
Бусад (бичнэ үү)	06

Өмчийн хэлбэр	Хувь	Код
Хувийн - Монгол улсын иргэний		21
Хувийн - Гадаадад хамтарсан	... %	22
Хувийн - Гадаад улсын		23
Төрийн өмчийн оролцоотой	... %	12
Төрийн хамтарсан	... %	13
Орон нутгийн өмчийн оролцоотой	... %	32
Орон нутгийн хамтарсан	... %	33

Хариуцлагын хэлбэр	Код
Хувьцаат компани	10
Хязгаарлагдмал хариуцлагатай компани	11
Бүх гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	20
Зарим гишүүд нь хариуцлагатай нөхөрлөл	21
Хоршоо	30
Төрийн өмчит үйлдвэрийн газар	40
Орон нутгийн өмчит үйлдвэрийн газар	41
Төрийн бус байгууллага	70
Бусад	80

Б. ОРЛОГО, ЗАРЛАГА

мян.төг

Үзүүлэлт	МД	Гүйцэтгэл
А	Б	1
1. Нийт орлого мөр 1 = мөр (2 + 9 + 12)	1	
Үндсэн үйл ажиллагааны орлого мөр 2 ≥ мөр (3+8)	2	
- амбулатороос орсон	3	
- лаборатороос орсон	4	
- оношилгооноос орсон	5	
- хэвтэж эмчлүүлсэнээс орсон	6	
- эм тариа, эмнэлгийн материал худалдсаны	7	
- эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж худалдсаны	8	
Үйл ажиллагааны бус орлого мөр 9 ≥ мөр (10 + 11)	9	
- түрээсийн орлого	10	
- туслах аж ахуй, үйлчилгээнээс орсон орлого	11	
Бусад орлого	12	
2. Орлогын эх үүсвэр, бүгд мөр13=мөр14+15+(19+23)	13	
- улс, орон нутгын төсвөөс	14	
- эрүүл мэндийн даатгалын сангаас мөр 15 ≥ мөр (16+18)	15	
амбулаторын тусламж үйлчилгээ	16	
хэвтэн эмчлүүлэх тусламж үйлчилгээ	17	
эмийн хөнгөлөлт	18	
- өөрийн хөрөнгөөс	19	
- хувь хүнээс	20	
- хувийн хэвшлийн байгууллагаас	21	
- гадаадын хөрөнгө оруулалт, зээл тусламжаас	22	
- бусад эх үүсвэрээс	23	

Б. ОРЛОГО, ЗАРЛАГА

мян.төг

Үзүүлэлт	МД	Гүйцэтгэл
3. Нийт зарлага	мөр 24 = мөр (25+63)	24
Үндсэн үйл ажиллагааны зардал	мөр 25=мөр[(26ч41)+(44ч62)]	25
- үндсэн ба нэмэгдэл цалин, шагнал, урамшуулал		26
- ажиллагчдад мөнгөн ба биет хэлбэрээр өгсөн тусламж, урамшуулал		27
- нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл		28
- борлуулсан эм тариа, эмнэлгийн материалын зардал		29
- борлуулсан эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн зардал		30
- эмчилгээнд зарцуулсан эм, эмнэлгийн хэрэгсэл		31
- зээлийн хүүгийн зардал		32
- сэлбэг хэрэгсэл		33
- цахилгаан эрчим хүч		34
- шатахуун, шатах тослох материал		35
- түлш (нүүрс, мод, бусад)		36
- дулаан эрчим хүч (уур, халуун ус)		37
- цэвэр, бохир ус		38
- нормын хувцас, зөөлөн эдлэл		39
- хоол		40
- түрээсийн зардал	мөр 41 = мөр (42+43)	41
барилга, байшин түрээсэлсний		42
машин, тоног төхөөрөмж түрээсэлсний		43
- тээврийн зардал		44
- албан томилолтын зардал		45
- шуудан холбооны зардал		46
- интернэтийн зардал		47
- мэргэжлийн (гадны) байгууллагаар үйлчлүүлсний төлбөр		48
- зар сурталчилгааны зардал		49
- урсгал засварын зардал		50
- интернэтээс бусад компьютерийн үйлчилгээний зардал		51
- бичиг хэргийн зардал		52
- өөрийн эзэмшлийн авто тээвэр болон өөрөө явагч тээврийн хэрэгслийн албан татвар		53
- газар, байгалийн нөөц ашигласны төлбөр		54
- даатгалын зардал		55
- үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын шимтгэл		56
- сургалтын зардал		57
- удирдлагын зардал		58
- ном, хэвлэлийн зардал		59
- хөдөлмөр хамгааллын зардал		60
- аж ахуй, хангамжийн зардал		61
- бусад зардал		62
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	мөр 63=мөр(64ч70)	63
- Дахин борлуулахаар худалдаж авсан барааны зардал		64
- торгуулийн зардал		65
- бусдад өгсөн гишүүнчлэлийн татвар, хандив		66
- бусдын буруутай үйл ажиллагааны улмаас учирсан хохирол		67
- гамшгийн улмаас учирсан хохирол		68
- гадаад валютын ханшийн зөрүүгийн бодит алдагдал		69
- бусад зардал		70
4. Ашиг, алдагдал	мөр71=мөр(1-24)	71
- ногдол ашиг		72
5. Амбулаторын үзлэгийн тоо		73
6. Лабораторын үзлэгийн тоо		74
7. Оношлогооны тоо		75
8. Хэвтэн эмчлүүлэгчдийн тоо		76
9. Эмнэлгийн орны тоо		77
10. Компьютерийн тоо		78

В. Ажиллагчдын тоо

Үзүүлэлт	МД	Бүгд	Үүнээс:		эмэгтэй
			Бүтэн цагаар	Бүрэн бус	
А	Б	1=2+3	2	3	4
Ажиллагчдын тоо	1				
Үүнээс: судалгаа, шинжилгээний ажиллагчид	2				
Ажилласан цаг	3				

Г. Материаллаг эргэлтийн хөрөнгийн нөөц

Үзүүлэлт	МД	Үнийн дүн (мян.төг)	
		Оны эхэнд	Оны эцэст
А	Б	1	2
Түүхий эд, материал	1		
Хагас боловсруулсан бүтээгдэхүүн (дуусаагүй үйлдвэрлэл)	2		
Бэлэн бүтээгдэхүүн	3		
Мал, амьтад	4		
Дахин борлуулахаар худалдан авсан бараа	5		
Сав баглаа, боодол	6		
Нийт нөөц мөр7=мөр(1ч6)	7		

Д. Хөрөнгийн нийт хуримтлал

мян.төг

Үзүүлэлт	МД	Оны эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Эх үүсвэрээр										Хасагдсан	Оны эцсийн үлдэгдэл
				Дотоодын	Төсвийн хөрөнгө оруулалт	Банкны зээл	Өөрийн хөрөнгө оруулалт	Бусад эх үүсвэр	Гадаадын	Гадаадын шууд хөрөнгө	Зээл	Гадаадын буцалтгүй тусламж	Бусад эх үүсвэр		
А	Б	1	2=3+8	3=4+7	4	5	6	7	8=9+12	9	10	11	12	13	14=1+2-13
Үндсэн хөрөнгө мөр1 = мөр(2+3+7+2+5+6)	1														
Орон сууцны барилга	2														
Бусад барилга, байгууламж мөр3=мөр(4 ÷ 6)	3														
- Орон сууцны бус барилга	4														
- Бусад байгууламж	5														
- Газар, хөрс сайжруулалт	6														
Машин, тоног төхөөрөмж мөр7=мөр(8 ÷ 10)	7														
- Тээврийн хэрэгсэл	8														
- Мэдээлэл, холбооны тоног төхөөрөмж	9														
- Бусад машин, тоног төхөөрөмж мөр10>=мөр11	10														
Үүнээс: Тавилга, эд хогшил	11														
Өсөж үрждэг хөрөнгө мөр12=мөр(13+14)	12														
- Мал, амьтад	13														
- Олон наст ургамал	14														
Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийг эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал	15														
Оюуны өмчийн бүтээгдэхүүн мөр16 = мөр(17 ÷ 19+22+23)	16														
- Судалгаа, шинжилгээний ажил	17														
- Геологи хайгуулын ажил	18														
- Компьютерийн программ хангамж, мэдээллийн сан мөр19= мөр(20+21)	19														
- Компьютерийн програм хангамж	20														
- Мэдээллийн сан	21														
- Утга зохиол, урлагийн эх бүтээл	22														
- Оюуны өмчийн бусад хөрөнгө	23														
Үнэт зүйлс мөр24=мөр(25 ÷ 27)	24														
- Үнэт металл, чулуу	25														
- Эртний эдлэл, гар урлалын бүтээл	26														
- Бусад үнэт зүйлс	27														

Захирал (Эзэн).....

Тамга тэмдэг Ерөнхий (ахлах)нягтлан бодогч.....

Эдийн засагч.....

МАЯГТ НӨХӨХ ЗААВАР

Энэ тайланг эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа эрхэлдэг санхүүгийн тайлан тэнцэл гаргадаг хувийн хэвшлийн байгууллага "Статистикийн тухай" Монгол Улсын хуулийн дагуу тогтоосон хугацаанд нь үнэн зөв, бүрэн нөхөж ирүүлнэ.

А. ХАЯГИЙН ХЭСЭГ

Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын жилийн мэдээний маягтын хаягийн хэсэг нь ҮСХ-ны мэдээллийн санд өөрчлөлт, баяжилт хийхэд чухал ач холбогдолтой мэдээлэл юм. Байгууллагын нэр гэсэн хэсэгт үүсгэн байгуулагч аж ахуйн нэгж, байгууллагын нэр болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын нэрийг нөхнө. Жишээ нь: "Бөрт -Ирээдүй" компанийн "Амар" эмнэлэг гэх мэт. Үндэсний татварын ерөнхий газар болон түүний орон нутаг дахь албанаас олгосон регистрийн дугаар, Эрүүл мэндийн сайд болон тухайн орон нутгийн ЭМГ-аас олгосон тусгай зөвшөөрлийн дугаарыг заавал нөхнө. Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, үйл ажиллагааны салбарын чиглэлийг ААНБ, кодуудыг аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нөхнө. Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын хариуцлагын хэлбэр, байгууллагын төрөл, өмчийн хэлбэрийн аль тохирохыг дугуйлж, хувийг бөглөнө. "Хувийн-гадаад улсын" гэсэн өмчийн хэлбэрийг 100 хувийн гадаадын хөрөнгө оруулалттай ААНБ дугуйлна. Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын төрлийг давхардуулахгүйгээр авна. Жишээлбэл: Хэрвээ эмэгтэйчүүдийн эмнэлэг нь ортой, амбулатор, лаборатортой бол хэвтэн эмчлэх эмнэлэг рүү орно. Учир нь ортой эмнэлгүүд дэргэдээ амбулатор, лаборатотой байдаг. Харин зөвхөн үзлэг хийдэг бол амбулатор гэсэн төрөл рүү орно.

Б.ОРЛОГО, ЗАРЛАГА

Мөр (1): Мөр 2; 9-ын нийт орлогын хэмжээг дүгнэнэ. Мөн мөр 1 нь мөр 13-тай тэнцүү байна.

Мөр (2): Мөр 3-аас мөр 8-д заагдсанаас орлогын хэмжээг дүгнэнэ.

Мөр (9): Мөр10-аас мөр 11-ийн орлогын хэмжээг дүгнэнэ.

Мөр (13): Мөр14, 15 болон мөр 19-өөс 23-ын орлогын хэмжээг дүгнэнэ.

Мөр (15): Мөр16-аас 18-ын нийлбэр байна.

Мөр (24): Мөр 25 ба 63-ын нийлбэр байна.

Мөр (25): Мөр 26-аас 41-ийн нийлбэр дээр 44-өөс 62-ийн нийлбэрийг нэмсэнтэй тэнцүү байна.

Мөр (41): Мөр 42 ба 43-ын нийлбэр байна.

Мөр (63): Мөр 64-өөс 70-ын нийлбэр байна.

Мөр (71): Мөр 1-ээс 24-ийг хассан ялгавар байна.

Мөр (26): Үндсэн ба нэмэгдэл цалин хөлс, түүнтэй адилтгах орлого, шагнал, урамшуулал, цалинд олгосон бүтээгдэхүүн, хоол түлээ нүүрс, байрны хөнгөлөлт зэрэг орно.

Мөр (29): Борлуулсан эм, тариа, боох материал, урвалж бодис гэх мэт зардал орно.

Мөр (30): Борлуулсан эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж гэх мэт зардал орно.

Мөр (36): Мод, нүүрс орно.

Мөр (48): Бүх төрлийн мэргэжлийн байгууллагаар үйлчлүүлсэний зардал орно. Жишээ нь: аудитын хяналт, зураг төслийн ажил, социологийн судалгаа хийлгэх г.м

Мөр (50): Эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахтай холбогдсон урсгал засвар, үйлчилгээний зардал орно. ЭМХХБ-ыг өргөтгөх, шинэчлэхтэй холбогдсон зардал нь капиталыг бий болгох зардал буюу хөрөнгө оруулалтанд тооцогдох тул энд орохгүй.

Мөр (56): Мөр 28-д заагдсанаас бусад даатгалын зардлыг оруулна. Жнь: хөрөнгийн даатгал г.м

Мөр (59): Байгууллагаас ажиллагчдыг сургаж, мэргэжил дээшлүүлэхэд зарцуулсан зардал болон сургалтын төлбөр, сургалт зохион байгуулсантай холбоотой гарсан зардал багтана.

Мөр (63): Мөр 26-62-д заагдсанаас бусад зардлын нийт дүнг нөхнө.

Мөр (71): Мөр 65-70-д заагдсанаас бусад зардлын нийт дүнг нөхнө.

В. Ажиллагчдын тоо, цалин

Ажиллагчид гэж цалин хөлс, орлого олох зорилгоор эдийн засгийн үйл ажиллагаанд оролцож, хөдөлмөр эрхлэлж буй иргэнийг хэлнэ. Олон улсын нэгдсэн ангиллын дагуу ажиллагчдыг бүтэн, бүрэн бус цагаар ажилладаг ажиллагчид гэж ангилна.

Бүтэн цагаар ажиллагчид гэж байгууллагын нийтээр хүлээн зөвшөөрсөн ажлын ердийн цаг, эсвэл хууль, тогтоомжийн дагуу хэвшсэн ажлын цагаар ажилладаг ажиллагчид. Мөн тухайн санхүүгийн жилийн турш бүтэн цагаар ажилласан ажиллагчдын сарын дундаж тоогоор ажиллагчдын тоог илэрхийлж болно.

Бүрэн бус цагаар ажиллагчид хөдөлмөрийн гэрээ болон ажил гүйцэтгэх, бусад гэрээний дагуу ажиллаж, долоо хоногийн ажлын цаг, ердийн ажлын өдрийн үргэлжлэлээс бага хугацаагаар ажилладаг ажиллагчдыг хамруулна (Цагийн ажил хийж буй хөдөлмөрийн насны суралцагчийг хамруулахгүй).

Г. Материаллаг эргэлтийн хөрөнгийн нөөц

Тайлант эсвэл тайлант хугацаанаас өмнө үйлдвэрлэсэн, борлуулахад бэлэн байгаа, эсвэл үйлдвэрлэлийн болон өөр бусад үйл ажиллагаанд хэрэглэхээр төлөвлөж байгаа бүтээгдэхүүнээс бүрдэх хөрөнгө юм.

Түүхий эд, материал (мөр 1) нь дахин борлуулахаар биш харин үйлдвэрлэлийн үйл ажиллагаандаа завсрын орцоор хэрэглэхээр төлөвлөж буй бүтээгдэхүүн орно.

Хагас боловсруулсан бүтээгдэхүүн (дуусаагүй үйлдвэрлэл) (мөр 2) нь аж ахуйн нэгж, байгууллагаас эдийн засгийн бусад нэгжүүдэд нийлүүлэхэд үйлдвэрлэл нь хараахан дуусаагүй байгаа үйлдвэрлэлээс бүрдэнэ.

Бэлэн бүтээгдэхүүнд (мөр 3) хэдийгээр уг бүтээгдэхүүнийг цаашид үйлдвэрлэлийн өөр боловсруулалтад завсрын хэрэглээгээр ашиглах байсан ч түүний үйлдвэрлэлийн бүх шатны үйл явц бүрэн дууссан бүтээгдэхүүнийг оруулна

Дахин борлуулахаар худалдаж авсан бүтээгдэхүүнд (мөр 5) аж ахуйн нэгж, байгууллага буюу бөөний болон жижиглэн худалдаачдын үйлчлүүлэгчдэд борлуулах зорилгоор худалдан авсан бараа байна.

Д. Хөрөнгийн нийт хуримтлал

Үндсэн хөрөнгө. Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нэгээс дээш жил давтан эсвэл үргэлжлэн ашигладаг хөрөнгө бөгөөд үүнд барилга, байгууламж, тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, газрын сайжруулалт, үржлийн мал, олон наст ургамал, оюуны өмчийн хөрөнгө багтана. 20-р дансны холбогдох дүнг тавина.

Орон сууцны барилга (мөр 2) аль ч улиралд хүн амьдрахад зориулагдсан болон зориулалтын бус барилга, автомашины гарааж зэргийг хамруулна. Тухайлбал, бүх төрлийн байшин, гэр, нийтийн зориулалттай байр, дотуур байр, усан онгоц болон нийтийн зориулалттай орон сууцыг мөн хамруулна.

Бусад барилга, байгууламж (мөр 3) нь орон сууцны бус зориулалттай үйлдвэр, үйлчилгээний барилга, байгууламж, далан, зам, гүүр, шугам, сүлжээ болон газар, хөрс сайжруулалтаас бүрдэнэ.

Машин, тоног төхөөрөмж (мөр 7) нь өрхийн эцсийн хэрэглээнд эзэмшиж байгаагаас бусад тээврийн хэрэгсэл тоног төхөөрөмжөөс бүрдэнэ. Харьцангуй бага үнэтэй болон тогтмол худалдан авдаг гар багаж зэргийг машин, тоног төхөөрөмжид оруулахгүй. Түүнчлэн орон сууцны болон орон сууцны бус барилгын бүтцэд хамрагддаг барилгын салшгүй хэсэг болох машин, тоног төхөөрөмжийг мөн оруулахгүй. Цэрэг дайны зориулалтаар худалдан авсан зэр зэвсгийн системээс бусад машин, тоног төхөөрөмжийг энд оруулна.

Өсөж үрждэг хөрөнгөд (мөр 12) байгууллагын шууд хяналт, удирдлагын дор үр төл болон үр жимсээ байнга давтан өгдөг мал амьтан, мод, ургамлыг хамруулна.

Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгийн эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардал (мөр 15) нь газар дээр түгээмэл тохиолддог. Үйлдвэрлэгдэхгүй хөрөнгөд газар, байгалийн нөөц, баялаг, ус, эрчим хүчний нөөц орно. Эзэмших эрх шилжихтэй холбогдсон зардалд дараах зардал багтана. Үүнд: Хөрөнгийг худалдан авч байгаа болон худалдаж байгаа хоёр талын мэргэжлийн үйлчилгээний бүх төлбөр, шимтгэ; худалдан авагчаас тусад нь нэхэмжилсэн худалдаа, тээврийн зардал; хөрөнгийн эзэмших эрх шилжүүлэхтэй холбогдон худалдан авагчаас төлөх бүх татвар; хөрөнгийг худалдахтай холбогдуулан төлөх аливаа татвар; худалдан авч байгаа болон худалдаж байгаа хөрөнгийн үнийн дүнд ороогүй угсрах, суурилуулах аливаа зардал; хөрөнгийн бүрэн бүтэн байдлыг хангах, тухайн хөрөнгийн байсан байгаль орчныг сэргээхэд шаардагдах аливаа зардал орно.

Оюуны өмчийн бүтээгдэхүүн (мөр 16) гэж биет шинж чанаргүй, хүний оюуны хүчин чармайлтаар бий болдог, нэг буюу түүнээс дээш жил ашиглагддаг, өөрийн эзэмшигчиддээ давуу болон онцгой эрх, өрсөлдөөний давуу талыг олгосон хөрөнгийг ойлгоно. Үүнд шинжилгээ судалгаа, хөгжлийн ажил, геологи хайгуулын ажил болон үнэлгээ, компьютерийн програм хангамж, мэдээллийн сан, утга зохиол, урлагийн эх бүтээл, лиценз, патент зэрэг орно.

Үнэт зүйлсийн хуримтлал (мөр 24) Үнэт зүйлсийг үнэт металл, чулуу; эртний эдлэл, түүх соёл, гар урлалын бүтээл; бусад гэж ангилна. Үнэт зүйлсийн хуримтлалд үйлдвэрлэл, хэрэглээнд ашиглагддаггүй, цаг хугацааны явцад хэрэглээний чанар эсвэл бодит үнэ цэнээ алддаггүй, үнэ нь улам нэмэгддэг зүйлс орно.

□□□□□□ □□□□□□□□ □□□□

о□□:327547